

**"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2024.05.30

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Үндэсний аудитын газраас "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийж, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах, цаашид гарсан алдаа дутагдлыг давтахгүй ажиллах, удирдлагыг холбогдох мэдээ, мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэлээ.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал**

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам"-ыг үндэслэв.

**Гурав. Танилцуулга**

Үндэсний аудитын газраас "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 07/809 дугаартай албан бичгээр аудитын тайланг хүлээн авч, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу "Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", төлөвлөгөөний биелэлтийг холбогдох баримт, материалын хамт хуулийн хугацаанд Үндэсний Аудитын газарт тус тус хүргүүлсэн.

"Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын албан шаардлага, зөвлөмж, төлбөрийн актын хүрээнд 21 арга хэмжээнд хяналт хийж, хэрэгжилтэд 2024 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн байдлаар үнэлгээ хийхэд **92** хувьтай бөгөөд **"Тодорхой үр дүнд хүрсэн"** зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй гэсэн үнэлгээтэй байна. Үүнд:

Албан шаардлагын хүрээнд **100** хувьтай **2**, **50** хувьтай **1**, Хугацаа болоогүй-**3**, зөвлөмжийн хүрээнд **100** хувьтай **5**, Хугацаа болоогүй-**8**, төлбөрийн актын хүрээнд Хугацаа болоогүй-**2** арга хэмжээ байна. Эдгээр 21 ажлын хэрэгжилтийг доорх хүснэгтээр харуулав.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр:

*/Нийт арга хэмжээний хүрээнд/*

*Хүснэгт 1.*

№	Шийдвэрийн төрөл	Тоо	100%	50%	Хугацаа болоогүй	Нийт %
1	Төлбөрийн акт	2	-	-	2	-
2	Албан шаардлага	6	2	1	3	<b>83,3%</b>
3	Зөвлөмж	13	5	-	8	100%
Нийт арга хэмжээ		21	<b>7</b>	<b>1</b>	<b>13</b>	<b>92%</b>

"Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын албан шаардлага, залруулга, зөвлөмж, төлбөрийн актын хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 29-ны байдлаар хяналт хийж, хэрэгжилтэд үнэлгээ өгсөн. Үүнд: Албан шаардлага 6, зөвлөмж 13-ыг өгч, төлбөрийн актаар барагдуулах 2 асуудлыг тайландаа тусгаж ирүүлсэн.